

РАДИОГИЙН МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ

С. Ганцэцэг*

* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: мэдээ, радио мэдээлэл, радио мэдээнд тавигдах шаардлага, мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч, сонсогч, үг.

Радио нь мэдээллийг шууд дамжуулах тохиромжтой, хүртээмжтэй, тогтмол, хямд төсөр сувгийнхаа хувьд Монголын ОНМХ-ийн тогтолцоонд онцгой байр эзэлсээр байна. Энэхүү мэдээллийн онцгой, өвөрмөц хэрэгсэл нь олон нийтийн тэр дундаа орон нутгийн хэрэглэгч, сонсогчдын өдөр тутмын мэдээлэл авдаг гол эх сурвалж нь юм. Тиймийн тул радио сэтгүүлчийн ур чадвар, сонсогчдоо хүндэтгэх, чанартай мэдээлээр хангах, тэдэнд мэргэжлийн болон сонсогчдын сэтгэл зүйг мэдрүүлж, бүтээлч шүүмжлэлийг хүргэж байх нь сэтгүүл зүйн "орчин" эрүүл байхад ихээхэн нөлөөтэй юм. Үүний зэрэгцээ мэдээлэл хүлээн авагчид буюу сонсогчид сэтгүүл зүйн өөрийн гэсэн тодорхой ойлголт, мэдлэгтэй, мэдээ, мэдээллийн чанарыг дүгнэж, цэгнэх зайлшгүй чадвартай байх шаардлагатай. Дээрх бодлын үүднээс бид сэтгүүл зүйн онолын ойлголт болоод радио сонсогчийн практик ажиглалтыг зэрэгцүүлэн үзсэн болно.

Чухал үйл явдлуудыг шуурхай мэдээлэх нь мэдээллийн төрөл зүйлийн үндсэн үүрэг, зориулалт байдаг. Үйл явдлын үндсийг баримт (факт) бүрдүүлдэг. Тийм учраас зохиомол бус, үнэхээр болсон үйл явдал, үзэгдэлд баттай суурилсан мэдлэг мэдээнд чухал. Яагаад гэвэл ямар нэгэн дүгнэлт хийхэд баттай үндэслэл хэрэгтэйгээс гадна аливаа зүйлийн урьдчилсан таамналын шалгуур болдог. Мөн бодитой, үндэстэй байх шаардлагатай.

Сэтгүүл зүйн факт гэдэг бол бодит амьдралд тодорхой байр сууринаас хандсан, нийгмийн сонирхлыг татаж буй, цаг үеийн чухал мэдээ юм. Янз бүрийн хэлбэрээр өгүүлсэн баримт, сэлтүүдийн тухай мэдээнүүд нь мэдээллийн төрлийн үндэс болдог. Ямарваа нэг үйл явдлын мэдээ нь болсон үйл явдлын тухай төсөөлөл өгөхүйц, түүний хөгжил, өрнөлийн тухай товч өгүүлэл байдаг.

Шинэ сэргэг мэдээ олох, тэдгээрийг боловсруулах, мэдээний хөтөлбөр зохиох нь радиогийн мэдээллийн албадын ажлын гол чиглэл байх учиртай. Ийм учраас төрөл зүйлийн онцлогийг авч үзэхийн өмнө мэдээний язгуур чанарын багтаамжтай шинжүүд дээр тогтож ярья.

Мэдээллийн асар их урсгал дотор ач холбогдлоороо мэдээ нэгдүгээр байр эзлэх нь маргаангүй. Байнга өөрчлөгдөж байгаа нийгэм, улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын дүр зургийг юуны өмнө мэдээ л зураглан үзүүлж чаддаг. Мэдээ нь нийгмийг үүрэгжүүлэхэд хамгийн чухал мэдээлэл болдог. Дэлхийн олон нийтэд мэдээллийг шуурхай хүргэхэд радио онцгой чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Радио нь мэдээллийг шууд дамжуулах тохиромжтой, хүртээмжтэй, тогтмол, хямд төсөр сувгийнхаа хувьд ОНМХ-ийн тогтолцоонд онцгой байр эзэлсээр байна. Радиогийн мэдээ нь нэвтрүүлгийн ихэнх цагийг эзэлдэг мэдээллийн урсгал юм. Энэ урсгал бүхэлдээ болж буй үйл явдлын дэлгэрэнгүй дүр зургийг бүтээдэг. Үүнийг амьд хөдөлгөөн, мэдээний тасралтгүй урсгал гэж болно.

Мэдээний ач холбогдол, багтаамж, эфирт өгөх янз бүрийн хэлбэр нь радиогийн нэвтрүүлгийн зохион байгуулалтыг тодорхойлдог.

"...Радио нэвтрүүлгийн нэн чухал онцлогуудын нэг нь хөтөлбөрт чанар (программность) буюу нэвтрэх давтамж байдаг. Радио мэдээ нь дүрслэн хэлбэл өдрийн программын "яс мод" болдог. Мэдээ нь энд тэнд саланги орвол сонсогчдын хүлээн авах сонирхлыг бууруулдаг. Тайлбар, тойм, янз бүрийн давхаргын хүмүүсийн яриагаар баяжуулбал сонирхолтой болно. Мэдээллийн хэлбэр олон янз

байх тусмаа сонсогчдод өгөөжтэй болдог"¹.

Дайчин шуурхай мэдээ нь мэдээллийн бодлогод төдийгүй, бусад программуудад ч нөлөөлдөг.

Манай мэдээллийн нэвтрүүлгийн түүх нь нийгмийн амьдралд гарч буй нийгэм, улс төрийн өөрчлөлтийг хурц тод тусгасаар ирсэн бөгөөд хамгийн гол нь мэдээллийн хэрэгслийн удирдлагаас сонсогчдод хандах хандлагыг тусгаж байдаг. Монголын радиогийн



Радиогийн мэдээ нь нэвтрүүлгийн ихэнх цагийг эзэлдэг мэдээллийн урсгал юм. Энэ урсгал бүхэлдээ болж буй үйл явдлын дэлгэрэнгүй дүр зургийг бүтээдэг. Үүнийг амьд хөдөлгөөн, мэдээний тасралтгүй урсгал гэж болно.



мэдээллийн нэвтрүүлгийг зохион байгуулах үндсэн зарчим нь мэдээллийн нэвтрүүлгийн практик, ажлын туршлагаар нэгэнт боловсрогджээ. Эдгээр зарчим нь олон улсын сэтгүүл зүй, түүний дотор сэтгүүл зүйн үндсэн зарчмуудтай нийцдэг.

Мөн өнгөрснийг ухамсарлах, сонсогчдоо судлах, сэтгэгдлийг нь ажиглах, сэтгэл зүйчдийн зөвлөгөө авах зэрэгт үндэслэгдсэн байдаг. Хамгийн гол нь улс төрийн уур амьсгалын өөрчлөлтөд үндэслэж байгаа нь баталгаа шаардахгүй үнэн юм.

Мэдээ нь юуны өмнө бодитой байхыг эрмэлзэх ёстой. Энэ нь мэдээний онцлог, мөн чанар болно.

Мэдээний редакцийн сурвалжлагчийн зорилго бол баримтыг мэдээлэх явдал. Тайлбар, үнэлэлт, дүгнэлтийг мэргэжилтнүүд, магадлан шинжээчид, тоймчид өгөх ёстой. Үүн дээр сэтгүүлчид асар их анхаарлаа хандуулж, ойлгох, өөрсдийгөө цэгнэх хэрэгтэй.

Харин үйл явдлын орчин, өнгө аяс зэргийг дүрслэн хэлэх нь сэтгүүлчийн үр чадвартай холбоотой.

Сонсогчид давын өмнө юуг анхаараад байна, ямар байр сууринаас хандаж, радио мэдээний агуулга, хэлбэрийг ямар хэмжүүрээр үнэлж цэгнэж байна вэ? Оросын онолчид мэдээний хэмжүүрийг тодорхойлохдоо:

- бодитой байх (объективность),
- шуурхай байх (оперативность),
- сайтар мэдэж байх (компетентность),
- цаг үеэ алдаагүй байх (актуальность),
- ойлгомжтой байх (понятливость)² гэж үзэж байна.

Мэдээ нь эдгээр чанар, шаардлагад үндэслэгдэх ёстой. Манай Монголын радиогийн хамгийн том мэдээллийн төв болох "Хурд" агентлагийн мэдээллүүд ч үүнд үндэслэгдсэн байна. Энэ нь мэдээ цуглуулах, сонгох, нэвтрүүлэх сэтгүүлчийн ажлыг тодорхойлох давхар үзүүлэлт гэсэн үг. Мэдээ нь хамгийн өргөн олон сонсогчдод зориулагдсан учраас нийгмийн амьдралын чухал чухал үйл явдал, асуудлуудын тухай мэдээллийг сонсогчдод ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилттой нягт уялдаатай үзэх нь зүйтэй. Хөтөлбөр зохиохдоо мэдээний орох газар, нэвтрүүлэх цагийг шинж чанараас нь хамаарч (өглөөний, өдрийн, оройн, шөнийн) харгалзах хэрэгтэй. Хугацаа нь (3-4 минутаас 10 хүртэл) агуулгынхаа сэдэвлэл зүй, өргөн дүр зураглал, үндсэн үйл явдлуудын гол шинж, өдрийн туршид тэдгээрийн өрнөх хөгжил, багтаамж ихтэй мэдээллийн сонсогчдод хүрч нөлөөлөх сэтгэл зүйн онцлог зэргийг тодорхойлдог.

Мэдээ эфирт тодорхой цагт тогтмол нэвтэрдэг нь сонсогчдын анхаарлыг татахад маш чухал хүчин зүйл болдог. Сонсогч хэзээ, хаана, шинэ мэдээ сонсохоо урьдчилан мэдсэн байдаг. "Хурд" агентлаг нь 06:05, 07:00, 08:00 гэх зэргээр 23 цаг хүртэл цаг тутам 5-25 минутын, голдуу 10 минутаар мэдээлэл нэвтрүүлдэг.

Мэдээ нь эхлэл хөгжимтэй байдаг нь түүнийг бусад нэвтрүүлгээс зааглаж ялгаж өгдөг. Мэдээний эхлэл хөгжмийг ойр ойрхон сольж өөрчлөх нь тийм зохистой биш. Сонсогчид нэгэнт дассан байдаг учраас эхлэл хөгжмийг сонсоод анхаарлаа мэдээнд хандуулж төвлөрүүлдэг.

Оросын радио сэтгүүл зүйн онолч В. В. Смирнов мэдээг хэмжээ, сэдэв, үйл явдлыг хамарсан хүрээ, ач холбогдол, шуурхай чанар зэргийг харгалзан дараах байдлаар ангилжээ.

- *Ерөнхий*. Энэ нь янз бүрийн мэдээлэл агуулдаг. Үйл явдлын хөдөлгөөнт, ерөнхий дүр зургийг хүргэх зорилготой хамгийн өргөн явагддаг хөтөлбөр юм. Ийм төрлийн хөтөлбөр нь гадаад, дотоодын байдлын тухай өргөн хүрээнд таниулдаг учраас сонсогчид их сонирхдог байна.

- *Сэдэвчилсэн*. Эдийн засаг, санхүү, урлаг, спортын салбарт болж буй үйл явдлыг салбар бүрээр нь бүлэглэн нэгтгэснийг хэлнэ. Тухайн салбарын байдлыг сонирхогч болон мэргэжлийн хүмүүсийн сонирхлыг их татдаг.

- *Тусгай*. Дэлхийн хэмжээний томоохон үйл явдал, тухайлбал, Олимп, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн г. м. томоохон үйл явдалд зориулагддаг. Тийм болохоор их дэлгэрэнгүй байдаг.

- Онцгой. Онцгой чухал үйл явдлын тухай шуурхай мэдээлэх"³ шаардлагаар нөхцөлдөн гарч ирдэг.

Мэдээнд сонголт их чухал үүрэгтэй. Хамгийн чухал, ач холбогдолтой, сонирхолтой байх нь мэдээний албаны ажлын гол хүчин зүйл болдог. Мэдээний сонголт, эвлүүлэг, өгөлт (подача) нь мэдээний албадын мэдээллийн бодлогыг бүрдүүлдэг. Мэдээ нь ур чадвар, туршлагаас гадна улс төрийн сонор сэрэмж, зөв чиг баримжаа шаарддаг бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бүтдэгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Дээрхи онолын асуудлын үүднээс Монголын үндэсний радиогийн "Хурд" агентлагийн мэдээллээс цухасхан авч үзье.

Монголын радио өдөрт 18 цагийн хөтөлбөртэй. Үүнээс 30 орчим хувийг гадаад, дотоодын өдөр тутмын мэдээ, мэдээлэл эзэлдэг.

Тус агентлаг нь 5 зүйлт мэдээллийн шалгуурыг 2002 онд баталжээ. Энэ нь онолын үндэслэл сайтай, орчин үеийн сэтгүүл зүйн шаардлагад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдөхүйц шалгуур үзүүлэлт юм.

Радиогийн онцлог, давуу талыг ашиглах тухайд, "Үйл явдлын талаар бүхнээс түрүүлж мэдэж, түүнийг болж байхад нь шууд сурвалжлах..." нь тун хомсхон байх шиг. Харин болж өнгөрсөн даруйд сонсогчдод мэдээлэх нь түгээмэл байдаг. Нэгэн зүйл гойд анзаарагдсан нь мэдээллийг аль болох тухайн орчин нөхцөл, уур амьсгал, дуу чимээтэйгээр газар дээрээс нь шууд сурвалжлахыг манай олонхи радио сэтгүүлч төдийгүй, бүхий л төрлийн мэдээллийн хэрэгслийн сэтгүүлч, сурвалжлагчид эрмэлзэхгүй байна. Юу

гэвэл, радио мэдээг ажиглахад 60-70 хувь нь албаны мэдээлэл бөгөөд шууд сурвалжилсан тохиолдол ховор байлаа. Монголын радиогийн ахмад сэтгүүлч, Соёлын гавьяат зүтгэлтэн, Л. Гүнсэн 3-4 жилийн өмнө нэгэн эрдэм шинжилгээний хурал дээр Монголын радиод сурвалжлагын төрөл "хээл хаялаа" хэмээн хатуухан хэлж байсан сан. Радио сурвалжлага нь эх сурвалж, тухайн нөхцөл байдлыг сонсголоор дамжуулан нүдэнд харагдаж, сэтгэлд буутал, бүр амтлах, үнэрлэх сэтгэгдэл төрөхүйцээр мэдрүүлэн дүрсэлдэг "айлчин" төрөл. Гэтэл манай сэтгүүлчид нэвтрүүлгийн эхлэлд цаасан дээрхи үгээ уншиж (уншуулж), араас нь тухайн хүнээс авсан яриа (синхрон)-гаа сонсоод дахин өөрөө юм уу, хөтлөгчөөр яриулах гэх мэтчилэн цуглуулсан мэдээллээ хоёр хувааж, нэг хэсгийг өөрөө, нөгөөг тухайн үйл явдлын эзнээр яриулан сөөлжүүлсэн маягтай хийчихээд түүндээ "сурвалжлага" гэж том нэр хайрлаад байх шиг. Тэгэхээр ямар ч амьд холбоо, харилцаа үүсэхгүй, сэтгэл хөдлөл, уран бодит дүрслэлгүй, сэтгэлд үлдэцгүй болно. Тухайн үзэгдэл, үйл явдлыг "дүрслэл"-ээр дамжуулан хүмүүсийн "чихэнд" зориулж хүргэж байгаагаа радио сурвалжлагачид мартаггүй байна.

Ер нь радио мэдээг ганцхан удаа сонсоод өнгөрнө гэдгийг ямагт санаж энгийн, богино өгүүлбэрээр, ярианы найруулгаар бичвэл мэдээ ойлгомжтой болдог гэж үздэг. Зарим судлаач нэг өгүүлбэр долоон үгнээс хэтрэхээрээ ойлгоход зовлонтой гэж тодорхойлсон нь олонх сонсогчдийн мэдээллийг хүлээн авах, ойлгох нийтлэг чадамжийн асуудлыг үндэслэн гарч ирсэн судалгаа юм.

"Хурд" агентлагийн "2005 оны төсвийн төслийн тухай" мэдээнд нэг өгүүлбэр ойролцоогоор 114 үгтэй байсан нь намайг цочиход хүргэсэн юм. Үүнийг сийрүүлбэл "Мэдэгдлийн гол стратеги нь Монгол улсын төсвийн тогтвортой, тэнцвэрт байдлыг олон улсын санхүүгийн байгууллагуудтай урьдчилан төхиролцсон төвшинд хүргэж, төсөв санхүүгийн дунд хугацааны шинэтгэлийг гүнзгийрүүлэх замаар улсын санхүүгийн

тогтолцоонд сүүлийн жилүүдэд бий болсон нааштай өөрчлөлтийг бататгах, эдийн засгийн өсөлтийг хангахын тулд татварын бодлогоор үйлдвэрлэлийг дэмжих, татварын баазыг өргөтгөн, татвар ноогдуулалт, төлөлтөнд

тавих хяналтыг сайжруулж, татвар хураах үйл ажиллагааг боловсронгуй болгох бодлого баримтлах, дунд хугацааны төсвийн гол тэнцвэрт харьцаа, түүний дотор төсвийн зарлагын хязгаарлалтыг эдийн засгийн бодит өсөлттэй уялдуулан хангах, улсын төсвийн зарлагын ачааллыг бууруулах, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар төсвийн нийт алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг үе шаттай бууруулах зарчмыг баримталсанд оршиж байгаа юм байна." (Мэдээллийн "Хурд" агентлагийн 2004 оны 4-р сарын 15-ны 14, 15 цагийн мэдээгээр нэвтэрсэн.)

Хэдийгээр нэвтрүүлэгч уг мэдээллийг сонсогчдод хүргэж уншсанд итгэж байгаа ч ийм урт үргэлжилсэн зүйлийг

хүмүүсийн "чихэнд" хүргэхэд тэр нэвтрүүлэгчээс чамгүй ур чадвар шаардсан нь дамжиггүй. Энэ нь баримтыг боловсруулаагүй, албархаг хийгээд мэргэжлийн үг хэллэг, нэр томьёог хянан, засаж найруулаагүйтэй холбоотой ноцтой алдаа юм.

Радио мэдээлэл нь тогтмол хэвлэлийн мэдээтэй төстэй, радио сэтгүүл зүйн бүх төрлөөс сонины төрөл зүйлд илүү ойр юм.

«
*Сонины мэдээ ХЭН, ЮУ,
ХЭЗЭЭ, ХААНА, гэсэн гол
асуултанд хариулдаг шиг радио
мэдээлэл үүнд хариу өгөхөөс
гадна Яаж, Ямар арга замаар
гэсэн нэмэлт асуултанд
хариулдаг.*

»

Сонины мэдээ **ХЭН, ЮУ, ХЭЗЭЭ, ХААНА** гэсэн гол асуултанд хариулдаг шиг радио мэдээлэл үүнд хариу өгөхөөс гадна **Яаж, Ямар арга замаар** гэсэн нэмэлт асуултанд хариулдаг. Сүүлийн хоёр асуултын хариуг манай сэтгүүлчид мөн л дутуу дулимаг, ихэнхдээ хүргэдэггүйг анзаарна буй за.

Үг бол мэдээ бичигч, сонсогч хоёрыг холбогч гүүр болдог. Ийм учраас өөрийн гол хэрэгсэл болсон үгийг зөв, оновчтой хэрэглэснээс бүх зүйл шалтгаалдаг. Эвгүй буруу **сонгосон** нэг үг байхад л чихэнд маш тод мэдрэгдэж тухайн өгүүлбэрийн утга, ач холбогдлыг маш их бууруулдаг. Жишээ нь: Нэгэн радио мэдээнд "...Төгрөгийн Америк доллартай харьцах ханш өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар **суларсан** байна" гэжээ. "Суларсан" гэдэг ганцхан оновчгүй үг тухайн мэдээллийн үнэ цэнийг жинхэнэ утгаар нь "сулруулж" буюу бууруулж байна.

Манай мэдээний сэтгүүлчид үйл явдлын орчин, уур амьсгал, өнгө төрх, сэтгэл хөдлөлийг нүднээ харагдтал дүрслэхийнхээ түрүүнд тухайн үйл явдал, үзэгдэлд үнэлэлт, дүгнэлт өгөх нь давамгайлаад байх шиг ажиглагддаг.

"Хурд" агентлагийн "Мэдээний шалгуур"-ын тавдугаарт: "Мэдээлэл бүр нь сэтгүүлчээс найруулан бичих, ярилцах, хөтлөхүйн их ур чадварыг шаардана" гэжээ. Мэдээж сэтгүүлч бүр өөрийн гэсэн найруулан бичих арга, өнгө аястай. Үүнийг орхиод, зөвхөн "ярилцах, хөтлөх ур чадвар"-ын тухайд ажиглахад, тухайн сэтгүүлчийн объектой харилцан ярьж, хөтлөн сурвалжилж байгаа нь маш ховор, харин сурвалжлагч мэдээллээ өөрөө уншиж сонсож байгаа нь элбэг байх юм.

Дээрх шүүмжлэлт ажиглалтыг эс тооцвол "Хурд" агентлагийн мэдээ, мэдээллийн хөтөлбөр нь сонсогчдод хэдийнээ танил болжээ. Мөн мэдээллийн эх сурвалж, баримт фактын нотолгоо сайтай байдаг нь тус мэдээллийн агентлагийн нэр хүндийг улам өргөдөг байна. Толгойн хөтөч лидүүд оновчтой, ойлгомжтой, сонсох сонирхлыг төрүүлэхүйц байдаг нь сайшаалтай. Мөн тодруулга, сэрэмжлүүлэг, зөвлөгөө, санамж зэрэг хэлбэр агуулгаараа ялгагдах, сонсогчдод цаг үеийг нь мэдрүүлсэн шинэлэг "бичил" төрөл зүйлүүд байгаа нь "Хурд"-ын өөрийн гэсэн өнгө төрхийг илтгэж байна.

Эцэст нь хэлэхэд, аливаа сэтгүүлч нь өөрийгөө мэргэжлийн хүний үүднээс хянаж, мэдээлэл хүлээн

авагчид буюу сонсогчдыг хүндэтгэн чанартай мэдээллээр цаг алдалгүй хангаж, олон түмнийг "Мэдээллийн эрин зуун"-д хөл алдалгүй, үнэн бодитой мэдээ, мэдээллээр үргэлж "баян" байлгах үүрэгтэй гэдгийг дахин давтан хэлмээр байна.

Ишлэл

¹ Смирнов В. В. 2002. Жанры радиожурналистики. М., с. 18.

² Там же, с. 59.

³ Там же, с. 76.

Ашигласан ном, материал

1. Смирнов В. В. 2002. Жанры радиожурналистики. М.
2. Менчер М. 2003. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс.
3. "Хурд" агентлагийн архив.

Резюме

В данной статье кратко рассматриваются проблемы информационного радиосообщения. Понятие "радиосообщения" очень широко по своему значению. Это обмен информацией между людьми или учреждениями и, наконец, сообщения с "горячих точек", полученные от корреспондента. Для нас интерес представляет именно оно, так как выражает один из главных жанровых признаков информационного радиосообщения.